

# АЖИЛТНЫ МЭРГЭШҮҮЛЭЛТИЙН ЖУРАМ — ЧУТ Ж01

## 1.1 ШААРДЛАГА, ХЭРЭГЦЭЭ

Ажилтны мэргэшүүлэлт бол баталгаажуулалтын угтвар нөхцөлийн хамгийн хариуцлагатай хэсэг юм. Үл эвдэх сорилтын үйлчилгээ нь техникийн шаардлага болон стандартын холбогдох заалтын дагуу хийгдэнэ. Тухайн шаардлагын баримт бичигт гүйцэтгэх ажилтан нь мэргэшсэн байх шаардлагыг тусгасан байх нь ч бий. ҮЭС-ыг чанарын шалгалтын хэрэгсэлээр ашиглаж байгаа лаборатори итгэмжлэгдэх шаардлагыг хангахыг хүсвэл MNS ISO/IEC 17025 стандартын холбогдох шаардлагуудыг хангах хэрэгтэй болох ба уул стандартын 5.2-р зүйл дэх ажилтанд тавих шаардлагад ҮЭС-ын ажилтан сертификаттай байхыг дурьдсан байдаг.

ҮЭС-ын гол зориулалт нь аюулгүй байдал, техникийн найдвартай ажиллагааг хангах явдал учраас түүний хэрэглээнд чанар хангалт тэргүүн зэргийн ач холбогдолтой. Ажлын зохион байгуулалт, гүйцэтгэл нь чанарын шаардлага хангах нэг шийдвэрлэх хүчин зүйл бол ажилтны мэргэжлийн өндөр ур чадвар, өөрөөр хэлбэл хүний хүчин зүйл.

## 1.2 НЭР ТОМЪЁО ТОДОРХОЙЛОЛТ

**Ерөнхий шалгалт:** ҮЭС-ын аргын үндсэн зарчмаар 1 буюу 2-р түвшний бичгийн шалгалт авах.

**ҮЭС-ын заавар:** ҮЭС-ын код, стандарт, техникийн шаардлага буюу ҮЭС-ын журмын дагуу сорилт хийх нарийн дэс дарааллын бичмэл тайлбар

**ҮЭС-ын арга:** Физикийн хуулийг үл эвдэх сорилтод хэрэглэх зарчим  
ЖИШЭЭ Хэт авианы сорилт явуулах

**ҮЭС-ын журам:** Код, стандарт, техникийн шаардлагын дагуу бүтээгдэхүүнийг эвдэхгүйгээр шалгахад ашиглах бүх параметр ба авах арга хэмжээний бичмэл тайлан.

**ҮЭС-ын аргын хэлбэр:** ҮЭС-ын аргын хэрэглээний өвөрмөц хэлбэр, техник  
ЖИШЭЭ Шингэн дэх хэт авианы сорилт явуулах

**ҮЭС-ын сургалт:** Баталгаажуулалт явуулах ҮЭС-ын аргаар онол, дадлага олгох явц болон албаар баталсан хөтөлбөрийн дагуу сургалт дамжаа явуулах хэлбэртэй байх боловч мэргэшүүлэх шалгалтад ашиглах сорьцыг сургалтын үед үл ашиглана.

**Суурь шалгалт:** Материал судлал, боловсруулах технологи болон согогийн төрлүүд, олон улсын энэ стандартын дагуу мэргэшүүлэх ба баталгаажуулах тогтолцоо, мөн 2-р түвшинд шаардагдах ҮЭС-ын аргын үндсэн зарчмуудын талаархи горилогчийн мэдлэгийг шалгах 3-р түвшний бичгийн шалгалт

**Шалгагч багш:** Албанаас шалгаж байгаа арга, бүтээгдэхүүн буюу үйлдвэрийн салбарт мэргэшүүлэх шалгалтыг хянах болон дүгнэх зөвшөөрөлтэй 3-р түвшний гэрчилгээ бүхий хүн

**Хянагч багш:** Горилогчийн ерөнхий, мэргэжлийн болон практикийн мэдлэг болон дадлагыг үнэлэхээр алба буюу итгэмжлэгдсэн мэргэшүүлэх албанаас зохион байгуулах шалгалтанд шууд хяналт тавьж ажиллах үл эвдэх сорилын мэргэжлийн хүн

**Мэргэжлийн шалгалт:** Тодорхой салбарт хэрэглэх сорилтын аргын хэлбэрийг ашиглан шалгах бүтээгдэхүүн ба түүнд холбогдох код, стандарт, техникийн шаардлага, журам, хүлцэх шалгуурын талаархи мэдлэгийг 1-р буюу 2-р түвшинд шалгах бичгийн шалгалт

**Мэргэшүүлэх шалгалт:** Горилогчийн ерөнхий, мэргэжлийн болон практикийн мэдлэг болон дадлагыг үнэлэхээр алба буюу итгэмжлэгдсэн мэргэшүүлэх албанаас зохион байгуулах шалгалт

**Сорьц:** Тодорхой хэрэглээний салбарт нийтлэг шалгагддаг бүтээгдэхүүнийг төлөөлөх боломжтой, радиографын зураг, өгөгдлийн бүрдэлийг багтаасан, дадлагын шалгалтад ашиглах дээж

**Хяналт :** Өөр ҮЭС-ын ажилтны шалгалтандаа хэрхэн бэлтгэж байгаа, шалгалтыг гүйцэтгэж үр дүнгийн тайлан хийж байгааг хянах үйл ажиллагааг багтаасан ҮЭС-ын хэрэглээг удирдан чиглүүлэх үйл ажиллагаа

### 1.3 ХОЛБОГДОХ СТАНДАРТЫН ЖАГСААЛТ

Энэхүү журмын баримт бичгийн бүтэц зохион байгуулалт агуулга нь доор иш татсан стандартуудын бүх шаардлагыг хангасан, эсвэл биелүүлэхэд чиглэгдсэн заалтуудыг агуулна:

1. MNS ISO 9712:2007, Үл эвдэх сорилт-Ажилтны мэргэшүүлэлт ба баталгаажуулалт
2. MNS ISO 20807, Үл эвдэх сорилт - Үл эвдэх сорилтыг хязгаарлагдмал ашиглах ажилтны мэргэшүүлэлт
3. ISO/TR 25107:2013, Үл эвдэх сорилт– ҮЭС-ын сургалтын хөтөлбөрийн гарын авлага ()
4. MNS ISO/TR 25108:2011, Үл эвдэх сорилт. Үл эвдэх сорилтын ажилтан бэлтгэх сургалтын байгууллагын удирдамж

## **1.4 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

### **Сургалт зохион байгуулалт**

ҮЭСМН нь MNS ISO 9712 болон MNS ISO/IEC 17024 стандартын холбогдох заалтын шаардлагыг хангаж ажилтны мэргэшүүлэлтийн үйл ажиллагаанд дараахь зарчим баримтлан оролцож байна. Үүнд:

- a) Ажилтны Баталгаажуулалтын Байгууллага (АББ) нь мэргэшүүлэх сургалтыг санал болгодоггүй ба ажил олгогчийн хүсэлтээр баталгаажуулалтын гэрээ байгуулж сургалтыг MNS ISO 9712 стандартыг баримтлан зохион байгуулна.
- b) Баталгаажуулалтын гэрээнд мэргэшүүлэх сургалт нь баталгаажуулалтын угтвар нөхцөл болохыг зааж сургалтын хөтөлбөрт иш татан, сургалт үргэлжлэх хугацааг тусгасан байна.
- c) ҮЭСМН-ээс зохион байгуулсан сургалт нь ажил олгогч байгууллагын ажлын байран дээрх сургалтыг орлохгүй юм гэдгийг сургалт захиалагчид ойлгуулсан байх зарчмыг баримтална.

### **Шалгалтын байр**

Ажилтны баталгаажуулалтын үндсэн шаардлагыг хангахын тулд ажилтны мэргэшлийн ур чадварыг үнэлж бичгийн болон дадлагын шалгалт авах үйл ажиллагааг зориулалтын байранд зохион байгуулах явдал юм. Тус байр нь MNS ISO/TR 25108 стандартын шаардлагыг хангасан байна.

АББ нь мэргэшүүлэх шалгалтыг дараахь байдлаар зохион байгуулж болно.

- ҮЭСМН нь шалгалтын төвд байгаа багаж, шалгалт тохируулгын болон дадлагын шалгалтын сорьц мэт шалгалт зохион байгуулах нөөц хангалттай үед мэргэшүүлэх шалгалтыг тус төвийг түшиглэн зохион байгуулна.
- Сертификат горилогч өөрийн багаж дээрээ дадлагын шалгалт өгөх хүсэлт гаргасан нөхцөлд ажил олгогчийн мэдлийн шалгалтын төвийг түшиглэн АЛБА-наас томилсон мэргэжлийн шалгагч багшийн хяналт дор мэргэшүүлэх шалгалтыг зохион байгуулна.
- Бүх төрлийн бичгийн шалгалтыг зөвхөн АББ-аас боловсруулсан буюу баталсан шалгалтын асуулт, баримт бичгийг ашиглан авна.
- АББ нь ҮЭС-ын хэрэглээний томоохон салбар тус бүр өөрийн эзэмшлийн шалгалтын төвтэй болохыг дэмжин зөвлөх үйлчилгээгээр хангана.
- Шалгалтын олон төвтэй болсон үед төв тус бүрт харьцуулагдахуйц шалгах хүндрэл бүхий төсөөтэй согогийг агуулсан шалгалтын сорьцуудтай байх шаардлага хангаж байхад хяналт тавьж ажиллана.

## **ШАЛГАЛТ ХУУРАМЧ БАЙДЛААР ЯВАГДАХААС СЭРГИЙЛЭХ АЖИЛЛАГАА**

- a) Шалгалтын өмнө горилогч өөрөө шалгалтын комисст хүчин төгөлдөр биеийн байцаалтаа үзүүлэх шаардлагатай
- b) Шалгагч болон хянагч багш нь шалгалтын материалыг хуурамчаар үйлдэх, засварлах эрхгүй
- c) Шалгагч болон хянагч багш нь АББ-ын зөвшөөрөл, хяналтгүй сорил авах ажилд оролцохыг хатуу хориглоно.
- d) Шалгагч нь шалгалтын байранд зөвхөн шалгалтын зохион байгуулалттай холбоотой зөвшөөрөгдсөн тусламжийг үзүүлэх үүрэгтэй.
- e) Горилогчоос урьдчилан танилцуулаагүй гэрээний заалтыг үндэслэн нууц задруулахгүй гэсэн амлалт авхуулах гарын үсэг зурахыг шаардахгүй байх
- f) Шалгагч болон хянагч багштай танилцахыг үл шаардана.
- g) Шалгалтын үр дүнд мониторинг хийж хуурсан үзүүлэлтийг илрүүдэг байх